



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/51

Арвайхээр сум

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Хэв шинжийг өөрчлөх тухай” 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын ерөнхий боловсролын “Тэмүүлэл-Эрдэм” сургуульд аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/367 дугаар захирамжаар олгосон тусгай зөвшөөрлийн 0003736 дугаар гэрчилгээний хавсралтад дурдсан сургуулийн хэв шинжийг “ердийн” гэснийг “гүнзгийрүүлсэн, төрөлжсөн” болгон өөрчилсүгэй.

2.Дээрх өөрчлөлтийн дагуу Арвайхээр сумын гадаад хэлний гүнзгийрүүлсэн, урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Тэмүүлэл-Эрдэм” сургуулийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтыг өөрчлөн, бичилтийг хийж сургалтын үйл ажиллагааг хэвийн зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газар (Н.Чимэддорж-Ойдов)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0110

D:My Doc. Zahiramj. Zasag darga